



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/2023

Улаанбаатар хот

Батлан хамгаалах яамнаас баримтлах
эрдэмтэн бэлтгэх бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.5, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого” баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2. “Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, үр дүнг тооцон ажиллахыг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл (Дэд сайд Б.Баярмагнай), шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, гадаад, дотоодын дэмжлэг, зээл, тусламжаар санхүүжүүлэхийг яамны Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1323100001

Батлан хамгаалахын сайдын 2023 оны
9-р дугаар сарын 27-ын өдрийн
102/2023-дугаар тушаалын хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНААС БАРИМТЛАХ
ЭРДЭМТЭН БЭЛТГЭХ БОДЛОГО**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалах болон боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, төрийн бодлого, батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх бодлого, хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй уялдсан эрдэмтний нөөц бүрдүүлэхэд баримтлах үндсэн баримт бичиг мөн.

1.2. Энэхүү бодлогын баримт бичиг нь Батлан хамгаалах салбарт эрдмийн зэрэгтэй хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангахаас гадна үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, төрийн цэргийн байгууллагуудад эрдэмтэн бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх замаар чанар, үр дүнд суурилсан бүтээлч, чадварлаг хүний нөөцийг бий болгоход чиглэнэ.

Хоёр. Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх
бодлогын зорилго, баримтлах зарчим

2.1. Бодлогын зорилго:

Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах судлал, аюулгүй байдлын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгаа хийх, сургалт явуулах оюуны мэдлэг, чадавхтай эрдэмтдийн нөөц бүрдүүлэх, тэднийг сургаж бэлтгэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, хөгжүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг хангаж, үр дүнтэй ашиглахад оршино.

2.2. Бодлогын зарчим:

2.2.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай уялдсан байх;

2.2.2. Төрөөс дээд боловсролын талаар баримтлах бодлоготой уялдсан байх;

2.2.3. Шинжлэх ухаанд суурилсан, технологийн хөгжил, инновацад тулгуурласан байх;

2.2.4. Орчин үеийн зэвсэгт тэмцэл явуулах арга, хэлбэрт гарч буй өөрчлөлт, үр дүнд хийсэн судалгаа, дүгнэлтэд үндэслэсэн байх;

Гурав. Эрдэмтэн бэлтгэх чиглэл

3.1. Цэргийн шинжлэх ухаан

3.2. Батлан хамгаалах судлал

3.3. Аюулгүй байдал судлал

Дөрөв. Эрдэмтэн бэлтгэх сургалтын тогтолцоо

4.1. Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх сургалтын тогтолцоо нь эрдэмтэн бэлтгэх зорилгыг хангахад үйлчилдэг удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалт, судалгаа, туршилтын орчин гэсэн харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагааны цогц байна.

4.2. Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх сургалтын тогтолцоо нь Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, төрийн цэргийн байгууллагуудтай харилцан уялдаатайгаар зохион байгуулагдах сургалтын үндсэн болон дэд тогтолцооноос бүрдэнэ.

4.3. Сургалтын үндсэн тогтолцоо гэдэгт Боловсрол, шинжлэх ухааны яамнаас тогтоосон чиглэлийн дагуу Үндэсний батлах хамгаалахын их сургууль дээр зохион байгуулах докторын сургалтыг ойлгоно.

4.4. Сургалтын дэд тогтолцоонд батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогод нийцүүлэн гадаад ба дотоодод докторын бусад сургалтад бодлогоор, системтэйгээр хамруулах асуудлыг авч үзнэ.

Тав. Эрдэмтнийг бэлтгэх арга хэлбэр

5.1. Сургалтын зохион байгуулалтаар нь өдрийн болон эчнээ сургалт;

5.2. Сургалтад хамрагдах хүрээгээр нь батлан хамгаалах байгууллагын ба төрийн цэргийн байгууллагын;

5.3. Сургалтын аргаар нь идэвхтэй, харилцан идэвхтэй буюу интерактив;

5.4. Сургалтын хэлбэрээр нь танхимын сургалт, зайн сургалт (online, offline), хосолсон;

5.5. Шатлалаар нь докторын сургалт, докторын дараах сургалт гэж ангилна.

Зургаа. Удирдлага, зохицуулалт

6.1. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын асуудлыг БХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөл хариуцаж, салбарын эрдэмтдийг бэлтгэх төлөвлөгөөнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, төрийн цэргийн байгууллагуудын захиалгыг тусгаж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулна.

6.2. БХЯ нь бэлтгэгдсэн эрдэмтдийнхээ нөөцөд шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид эрдэмтэн бэлтгэх хэрэгцээ шаардлага, хэтийн төлөв, сургах чиглэлд 3 жил тутам тодотгол хийнэ.

6.3. Эрдмийн зэрэг хамгаалсан докторуудаас докторын дараах сургалтад бодлогоор сонгон авч, 5 жил тутам 3-аас доошгүй шинжлэх ухааны докторыг бэлтгэнэ.

6.4. Эрдэмтнийг бэлтгэх ҮБХИС-ийн чиг үүрэг

6.4.1. ҮБХИС нь докторантурын сургалтыг чанартай, тасралтгүй зохион байгуулах, оюуны өндөр чадавхтай, мэргэшсэн, эрдмийн зэрэгтэй багш нараар сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл заалгаж, эрдэмтэн бэлтгэх үүргийг хэрэгжүүлнэ.

6.4.2. БХЯ-ны ШУТЗ-өөс жил бүр 5 хүртэлх офицер (35 хүртэл насны)-ын судалгааны ажлын сэдвийг нь баталж, сонгон шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд ҮБХИС-ийн докторантурт өдрийн сургалтад хамруулна. ҮБХИС-ийн докторантурт өдрөөр суралцагч нарын сургалтын төлбөрийг БХЯ хариуцна.

6.4.3. 6.4.2-д зааснаас бусад офицер, ахлагч, энгийн алба хаагч нь ҮБХИС-ийн докторантурын сургалтад төлбөртэйгөөр суралцана.

6.4.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, төрийн цэргийн байгууллагуудын захиалгаар эрдэмтдийг байгууллагын зардлаар эсвэл хувь хүний зардлаар нь сургаж, бэлтгэж болно.

6.4.5. Докторант нь суралцах хугацаандаа батлагдсан сэдвийнхээ хүрээнд ҮБХИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд оролцож, шинжлэх ухааны танин мэдэхүйн бүтээлч арга зүй, судалгааны ажлын арга барил эзэмшинэ.

6.4.6. ҮБХИС-ийн номын санд эрдэмтдийн бүтээл, судалгааны ажил(нууцын зэрэглэлгүй)-ыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, тэдгээрийг эрдэмтэд, судлаачид өдөр тутмынхаа ажилд тогтмол хэрэглэх, мэдлэгээ дээшлүүлэх, оюуны чадавхаа хөгжүүлэхэд ашиглах, судалгааны эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлнэ.

6.5. Эрдэмтнийг гадаад улсын цэргийн академи, их сургуульд бэлтгэх нь

6.5.1. Батлан хамгаалахын тулгамдсан асуудал, эрэлт хэрэгцээ, хэтийн бодлогод тулгуурлан гадаад улсад техник, технологи, инновацын чиглэл болон шинжлэх ухааны нэн шаардлагатай бусад чиглэлээр жилд 2 хүртэл доктор (Ph.D), 4 жил тутамд 1 доктор (Sc.D)-ыг бэлтгэнэ.

6.5.2. Цэргийн хамтын ажиллагаатай улс орнуудад сургалтын гэрээний үндсэн дээр хөнгөлөлттэй нөхцөл ба буцалтгүй тусламжийн хүрээнд ахисан түвшинд суралцуулах асуудлыг тухайн жилийн хамтын ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу хэрэгжүүлнэ.

6.6. Бэлтгэгдсэн эрдэмтдийг байршуулах, хөгжүүлэх чиглэл

6.6.1. Гадаад, дотоодын цэргийн академи, их сургуульд доктор болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийг БХЯ, ЗХЖШ-ын хөгжлийн бодлого боловсруулах болон ҮБХИС-ийн мэргэжлийн тэнхимүүдийн сургалт судалгааны ажилд биечлэн оролцуулах, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний үндсэн ажилтнаар тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтална.

6.6.2. Албан ажлын хэрэгцээ, шаардлагыг харгалзан хууль тогтоомжийн дагуу докторын зэрэгтэй хүний нөөцийг сэлгэн болон шилжүүлэн ажиллуулна.

6.6.3. Бэлтгэгдсэн эрдэмтэн нь докторантын эрдэм шинжилгээний ажлыг удирдаж, шинэ мэдлэг, шинэлэг үр дүн, ач холбогдолтой нэг сэдэвт бүтээл хамгаалуулах замаар энэхүү бодлогыг дэмжинэ.

6.6.4. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд цэргийн эрдэмтдийг гадаадын улсад судлаач солилцоогоор ажиллуулах, гадаадад зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалтад хамруулах замаар тэдний мэдлэг, боловсролыг нь дээшлүүлж, хөгжүүлнэ.

6.6.5. Докторын зэрэгтэй алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх,

шаардлагатай хөрөнгө, нөөцийг байгууллагын төсөвт жил бүр тусган зориулалтын дагуу зарцуулна.

6.6.6. Байгууллагын саналаар зарим чухал шаардлагатай мэргэжлийн эрдэмтдийг алба хаах насны дээд хязгаарт хүрсэн ч сургалт, судалгааны байгууллагад дахин сунгаж ажиллуулж болно.

Долоо. Санхүүгийн эх үүсвэр

7.1. Аюулгүй байдал, цэрэг, батлан хамгаалах чиглэлээр эрдэмтэн бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр:

- Улсын төсөв
- Зэвсэгт хүчний хөгжлийн сан
- Төлбөртэйгөөр докторантурт суралцагчдын сургалтын төлбөр
- Гадаадын төсөл, хөтөлбөр
- Бусад эх үүсвэр

Найм. Бодлогын хэрэгжилтэд тавих хяналт

8.1. БХЯ-ны ШУТЗ-ийн дарга, яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга нар Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

8.2. Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлогын хэрэгжилтийн үр дүнг 3 жил тутам Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

---oOo---